



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№41 /255/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.03.01

Цаг үе, үйл явдал

ОПЕРАТИВЫН ЖИЖҮҮРҮҮДИЙН ЦУГЛАРАЛТ БОЛЛОО

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу Агаарын цэргийн анги, салбаруудын оперативын жижүүрүүдийн цугларалт 2 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн байрлалд зохион байгуулагдлаа.

Агаарын цэргийн хуулиар хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилтийг хангахад гол үүрэгтэй офицер, ахлагч нарын албаны болон мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Агаарын цэргийн өнөөгийн үйл ажиллагаа, хөгжлийн хэтийн зорилго зорилт, анги, салбаруудын байлдааны жижүүрлэлтийн одоогийн байдал, хувь хүний хөгжлийн хандлага зэрэг сэдвээр Агаарын цэргийн командлалын мэргэжилтнүүд илтгэл тавьж, үйл ажиллагаатай холбоотой хэлэлцүүлэг өрнүүлэн цаашид анхаарах асуудлуудыг хэлэлцлээ.

Ахмад Б.НАНДИНЦЭЦЭГ



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

| ӨДӨР | ШӨНӨ |
|------|------|
| -2 | -22 |

ӨМНӨД СУДАН

| ӨДӨР | ШӨНӨ |
|------|------|
| 32 | 24 |

ВАЛҮТЫН ХАНШ

| ВАЛҮТ | АВАХ | ЗАРАХ |
|-------|----------|---------|
| USD | 2,873.00 | 2,877.0 |
| EUR | 3,215.0 | 3,245.0 |
| CNY | 454.00 | 456.00 |
| RUB | 35.00 | 36.50 |
| JPY | 24.80 | 25.00 |
| KRW | 2.39 | 2.41 |

ЗУРХАЙ



2022.03.01 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 29/

ХАВРЫН ТЭРГҮҮН ХАР БАР САРЫН ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал:

Сүлд тэнэж одно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

07.34-18.36

БАРИЛДЛАГА:

Үхэх

Шүтэн барилдлага:

Өтлөх үхэхүй

Суудал: Шороо

Энэ өдөр могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, угаал үйлдэх, мал арилжих, гэр бүрэхэд сайн. Улааны үйлд муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой.

Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой.

Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

60 КМ-ИЙН МАРШ ҮЙЛДЭВ



Зэвсэгт хүчний 110 дугаар анги

Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу хээрийн гаралт полигоны дадлагыг 2 дугаар сарын 16-23 өдрүүдэд Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн сургалтын төвийн районд зохион байгууллаа. Сургалтын төгсгөлд "Десант хорлон сүйтгэх бүлэгтэй тэмцэх, командын байрыг хориглон хамгаалах инженер сапёрын ротын ажиллагаа" сэдвээр ББТХС-ийг төлөвлөсөн бөгөөд бие бүрэлдэхүүн байнгын болон ХЦАХ-чдын гэсэн 2 маршрутаар 60 км-ийн явган маршийг амжилттай үйлдсэн юм.

Тус сургууль нь офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын дадлага, ур чадвар, бие бялдар, тэсвэр хатуужил, сэтгэл зүйн бэлтгэл, байлдааны зэвсэглэл, техник, тэсрэх бодистой харьцах дадлагыг дээшлүүлсэн, ангийн үүрэг гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлсэн үр дүнтэй сургалт боллоо.

Ахлах дэслэгч Д.ДАВААЖАРГАЛ

"ОЮУТАН ЦЭРЭГ" БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТИЙГ 3/1-3/10 ХООРОНД ЦАХИМААР АВНА

Онлайн үйлчилгээ



www.e-mongolia.mn

Тус сургалтад бүртгүүлэх хүсэлтийг 3 дугаар сарын 1-10-ны хооронд "e-Mongolia" платформоор авна.

Шалгуур нь:

- 18 нас хүрсэн, магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн нэгдүгээр дамжааны оюутан байх
 - Сурлагын голч дүн нь 2,8-аас дээш байх
 - Эрүүл мэнд, бие бялдарын хөгжлийн түвшинг гол шалгуур болгоно.
- Тус үйлчилгээ нь 2022.03.01 өдөр нээгдэж, 2022.03.10-ны орой хаагдана.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН

2,271,548 /69.8%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН

2,172,909 /66.8%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН

1,023,271 31,5%
102,635 /3,2%/

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

8310 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

122

ЭДГЭРСЭН

8069

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 435,994,531

Эдгэрсэн

Нийт: 366,533,745

Нас барсан

Нийт: 5,968,034



Цахим шууданд

ХЭЭРИЙН ГАРАЛТ, ПОЛИГОНЫ ДАДЛАГА ЭХЭЛЛЭЭ



Нэгтгэлийн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу бэлэнбайдлыг хангах "Цугларалт" дадлагын дохиогоор ажиллаж төлөвлөгөөний дагуу тактик, тусгай бэлтгэлийн цогцолбор 30 километрийн явган маршийг нэгтгэлийн хээрийн гаралттай уялдуулан үйлдлээ. Явган маршийн явцад тактикийн норматив,

байлдааны зэвсэг техникийн үүрэг зориулалт, өвчтөн шархтанд үзүүлэх анхны тусламж зэрэг хичээлүүдийг явуулсан юм. Энэ удаагийн 30 км-ийн маршийн үеэр нэгтгэлийн ажилтан албан хаагчдын зөвлөл түр амралтын районд байнгын болон ХЦАХ-д халуун хоол, аарцаар үйлчилж хамтран ажиллалаа.



ТУРШЛАГА СУДЛАХ УУЛЗАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

ЗХЖШ-аас зохион байгуулж буй "Сэтгэл зүйч, хүний хөгжлийн менежер бэлтгэх мэргэжүүлсэн сургалт"-д хамрагдаж буй офицер, ахлагч нар ЦДБЭЧ-ын үйл ажиллагаатай танилцах уулзалтыг зохион байгууллаа.

Уулзалтын эхэнд ЦДБЭЧ-ын дарга хурандаа Г.Золзаяа Зэвсэгт хүчний анги, салбаруудад соёл хүмүүжлийн ажлыг удирдан зохион байгуулах, алба хаагчдын сэтгэл зүйн боловсролыг хөгжүүлэн ажиллах их үйлст нь амжилт хүсэж, ЦДБЭЧ соёл хүмүүжлийн ажилтнуудын хамтын ажиллагааг салшгүй холбоотой байдгийг тодотгон хэлсэн юм. Уулзалтын үеэр ЦДБЭЧ-ын үндэсний



хөгжимчид урлагийн мэндчилгээ дэвшүүлсний зэрэгцээ Зэвсэгт хүчний хэмжээнд болон байгууллагын албаны дарга дэд хурандаа Р.Өнөржаргал илтгэл тавьж, нээлттэй харилцан ярилцлага асуудлууд, олон нийтийн арга

хэмжээг зохион байгуулах туршлага арга зүй сэдвээр ЦДБЭЧ-ын Сургалт, соёл хүмүүжил, маркетингийн албаны дарга дэд хурандаа Р.Өнөржаргал илтгэл тавьж, нээлттэй харилцан ярилцлага хийсэн юм.

ЦЭРГИЙН ЧУУЛГЫНХАН II САРЫН АЖЛАА ДҮГНЭВ



ЦДБЭЧ-ын хамт олон II сарын ажлаа дүгнэж, "Цэргийн тангараг" давтах, Төрийн дууллаа дуулах хүндэтгэлийн ажиллагааг зохион байгууллаа.

Тус чуулгын удирдлага, хамт олон өнгөрөгч сард төлөвлөгөөт арга хэмжээнүүдийг амжилттай хэрэгжүүлж, удирдлага төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулан батлуулах, төрийн албан хаагчийн хувийн хэрэгт баяжилт хийх, 90 жилийн түүхт ойгоо угтсан хэсэгчилсэн тоглолтуудыг зохион байгуулах зэрэг ажлуудыг өрнүүлсний зэрэгцээ эмэгтэй энхийг сахиулагчдын чуулга уулзалтын болон Монгол цэргийн өдөрт зориулсан хүндэтгэлийн тоглолтуудын бэлтгэл ажлуудыг хангасан өрнүүн ажлын сар байлаа.

"АЛДАР" СПОРТ ХОРОО

АЛТАН МЕДАЛЬ ХҮРТЛЭЭ



Яшар Дугу, Вэхби Эмре, Хамит Каплан нарын нэрэмжит бөхийн төрлүүдийн дэлхийн чансааны оноо олгох тэмцээн 2 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд Туркийн нийслэл Стамбул хотод болж өндөрлөлөө.

Уг тэмцээнд Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны гавьяат тамирчин Г.Мандахнаран дасгалжуулагчтай баг тамирчид амжилттай оролцов.

Тодруулбал, эрэгтэйчүүдийн 65 кг-ийн жинд ОУХМ Ц.Цогбадрах, 70 кг-ийн жинд ОУХМ Г.Ханбүргэд, эмэгтэйчүүдийн 62 кг-ийн жинд гавьяат тамирчин С.Цэрэнчимэд нар оролцсон бөгөөд "Ташкент-2014" ДАШТ-ий алт, "Лас-Вегас-2015" ДАШТ-ий мөнгөн медальт, "Алдар" спорт хорооны тамирчин, Монгол Улсын гавьяат тамирчин ахлах ахлагч С.Цэрэнчимэд алтан медаль хүртэв.

БАЙГУУЛЛАГЫН НИЙЛБЭР ДҮНГЭЭР АМАН ХҮЗҮҮНД ...



2022 оны тэшүүрийн насанд хүрэгчдийн УАШТ өнгөрөгч сарын 26-27-ны өдрүүдэд Хандгайтын мөсөн гулгуурын талбайд боллоо. Тус тэмцээний 500, 1500, 3000 метрийн зайд болон 4 зайн нийлбэр дүнгээр ОУХМ дэд ахлагч Я.Зоригтбаатар,

ОУХМ Б.Гэрэлтуяа нар I байрт шалгарлаа. Мөн тамирчин Б. Мөнхбат 3000 метрийн зайд III байр, 5000 метрийн зайд I байр эзэлсэн амжилт үзүүлж, байгууллагын дүнгээр "Алдар" спорт хороо II байрт шалгарсан юм.

"АЛДАР"-ЫН БӨХЧҮҮД ӨНГӨЛӨВ



"Монгол Улсын начин цолны хүндэтгэл" үзүүлэх улс, аймгийн алдар цолтой 256 бөхийн барилдаанд Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны 24 бөх барилдсанаас Архангай аймгийн Цэнхэр сумын харьяат, "Алдар" спорт хороо, "Нутгийн буян" групп, "Бөхбилэг" дэвжээний бөх, улсын гарьд М.Бадарч

түрүүлж, Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын харьяат, "Алдар" спорт хороо, "Атар трейд" ХХК, "Таван-Хан" дэвжээний бөх, улсын харцага Б.Орхонбаяр үзүүрлэв. Их шөвөгт Ховд аймгийн Зэрэг сумын харьяат, "Алдар" спорт хороо, "Монтед" констракшн, "Ховд" дэвжээний бөх улсын харцага Б.Бат-Өлзий шалгарлаа.